

БАТЛАВ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ГЭРЭЛЧИМЭГ

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах эзэн
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а) байгууллагын албан ёсны цахим хуудас; b) сошиал сувгууд; c) дотоод сүлжээ; d) хэвлэл мэдээллийн хэрэгсэл; e) мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц; f) бусад /салбар байгууллагууд/ хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүртэл;	Жилийн турш	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүр тайлагнадаг байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Б.Алтанцэцэг Б.Орхонтуяа
		1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах. /2-оос доошгүй/	Жилийн турш	-Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; -Үр дүнг тооцсон байх.	Б.Алтанцэцэг
		1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага,	Эхний улирилд багтаан	-Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу батгалгаат эх сурвалжаас авсан байх;	Б.Алтанцэцэг Б.Орхонтуяа

		сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах.		-Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; -Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	
		1.4. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж олон нийтэд хүргэсэн байх.	Жилийн турш	-Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; -Авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилсан байх; -Олон нийтэд түгээсэн байх;	Б.Алтанцэцэг Б.Орхонтуяа
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. Аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын жагсаалтыг гарган, уулзалт зохион байгуулж, тулгамдаж буй асуудлаа хэлэлцэх, шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газраас цахимаар зөвлөмж авч ажиллах.	Жилийн турш	-Салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; -Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож тайлагнасан байх.	Б.Алтанцэцэг Б.Орхонтуяа
		2.2. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах.	Жилийн турш	-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар мэдээлэх; -Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээ авах;	

				-Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.	
		2.3.Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хагас, бүтэн жилээр тайлагнах, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших.	Жилийн турш	-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж тайлагнах; -Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; -Иргэд, олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.	Б.Алтанцэцэг
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухай байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах.	Жилийн турш	-Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийг талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; -Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; -Хэрэжилтийг тайлагнах.	Б.Алтанцэцэг
		3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх.	Жилийн турш	-Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших; -Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;	Б.Алтанцэцэг

				-Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх.	
		3.3.Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх	Жилийн турш	-Төлөвлөгөөний 1.1-1.3 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; -Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх; -Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн ажлын өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх.	Б.Алтанцэцэг Б.Орхонтуяа